

**Монгол Улсын Боловсрол, Соёл Шинжлэх Ухааны Яам
Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль**

Чимэдийн МАНДАЛСАЙХАН

**БЗДХ/ХДХВ/ДОХ-ЫН ТАЛААРХ ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБАН
ХААГЧДЫН СУРГАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

Е-720001 - Нийгмийн эрүүл мэнд

Сувилахуйн магистрын зэрэг горилсон бүтээл

**Улаанбаатар хот
2009 он**

**Монгол Улсын Боловсрол, Соёл Шинжлэх Ухааны Яам
Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль**

Гар бичмэлийн эрхтэй ©

Чимэдийн МАНДАЛСАЙХАН

**БЗДХ/ХДХВ/ДОХ-ЫН ТАЛААРХ ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБАН
ХААГЧДЫН СУРГАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

Е-720001 - Нийгмийн эрүүл мэнд

Эрдэм шинжилгээний ажлын удирдагч:

Нийгмийн эрүүл мэндийн магистр (МРН) Ө.Ганчимэг

Эрдэм шинжилгээний ажлын шүүмжлэгч:

Анагаах ухааны доктор (Ph.D), дэд профессор Б.Хандсүрэн

Улаанбаатар хот

2009 он

ГАРЧИГ

Агуулга	3-4
Товчилсон үгийн жагсаалт	5
Нэгдүгээр бүлэг Удиртгал	
1.1 Судалгааны ажлын үндэслэл	6-7
1.2 Судалгааны ажлын зорилго	8
1.3. Судалгааны зорилт	8
1.4. Хамгаалахаар дэвшүүлж буй асуудал	8
1.5. Судалгааны ажлын шинэлэг тал	8
1.6. Судалгааны ажлын практик ач холбогдол	9
1.7. Судалгааны үр дүнг хэлэлцүүлсэн байдал	9
1.8 Судалгааны ёс зүйн байдал	9
1.9. Судлагдсан байдал	10
1.10. Зохиолын бүтэц хэмжээ	11
Хоёрдугаар бүлэг. Судалгааны загвар арга зүй	
2.1. Судалгааны загвар	12
2.2. Мэдээ мэдээлэл цуглуулсан арга	12
2.3. Түүвэр түүвэрийн нэгж	13
2.4. Судалгааны явц	14
2.5. Судалгааны хязгаарлагдмал байдал	15
2.6. Судалгааны дэвшүүлсэн таамаглал	15
2.7. Мэдээ мэдээллийн боловсруулалт	15
Гуравдугаар бүлэг Хэвлэлийн тойм	
3.1. БЗДХ/ХДХВ/ДОХ-ын тархалтын өнөөгийн байдал	16-17
3.2. . БЗДХ/ХДХВ/ДОХ-ын талаарх мэдлэг, хандлага, дадлын талаар хийгдсэн судалгааны дүнгээс	18-19
3.2.1. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа	19-16
3.2.2. Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд	16-21
Дөрөвдүгээр бүлэг Судалгааны үр дүн	
4.1 Судалгаанд хамрагдагсдын ерөнхий мэдээлэл.	21-25
4.2. Судалгаанд хамрагдсан хугацаат цэргийн албан хаагчдын БЗДХ, ХДХВ, ДОХ-ын талаарх мэдлэг, хандлага, дадал	26
4.2.1. БЗДХ/ХДХВ/ДОХ-ын талаарх мэдлэг	29-35
4.2.2. . БЗДХ,ХДХВ, ДОХ-ын талаарх дадал	31-32
4.2.3. БЗДХ/ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх хандлага	37-40
4.2 Хугацаат цэргийн албан хаагчдын БЗДХ, ХДХВ, ДОХ-ын талаарх сургалтын хэрэгсэл, агуулгын байдал, сургалтын хэрэгцээ Сургалтын орчин нөхцөлийн үнэлгээ	40-46
Тавдугаар бүлэг Хэлцэмж	47
Дүгнэлт	48
Практик зөвлөмж	49
Ном зүй	50-54
Хавсралт	

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УДИРТГАЛ

1.1. Үндэслэл

Монгол улсад төдийгүй дэлхий нийтийн хүн амын эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг нь бэлгийн замаар дамжих халдвар, дархлалын олдмол хомсдол, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтын асуудал юм. Дэлхий нийтэд 2007 оны байдлаар ХДХВ/ДОХ-оор 33 сая хүн өвчлөөд байв. Нийт халдвар авсан хүмүүсийн 40 гаруй хувийг 15-24 насны залуучууд эзэлж байна.

Манай хөрш зэргэлдээ орнуудад ХДХВ/ДОХ-ын халдвар жилээс жилд нэмэгдэж, 2006 оны байдлаар БНХАУ-д уг өвчнөөр 650000 хүн өвчлөөд байгаа ЗХУ-д 100000 хүнд 205,7 хүн өвчилжээ. Манай улсын хөрш зэргэлдээ орших Эрхүү мужид 100000 хүнд 617,5 хүн буюу 15773 тохиолдол бүртгэгдээд байна.

Монгол улсад БЗДХ-ын өвчлөл жил тутам нэмэгдэж, 2008 оны эхний 12 сарын байдлаар нийт 17648 бэлгийн замын халдварт өвчний тохиолдол бүртгэгдсэнээс 36,9% трихомониаз, 34,8% нь заг хүйтэн, 28,2% тэмбүү өвчин тус тус эзэлж байна. ХДХВ/ДОХ-ын 55 дахь тохиолдол мөн онд илрээд байна.¹

ХДХВ/ БЗДХ-ын эсрэг үндэсний хариу арга хэмжээний цогц үнэлгээний тайланд олон хүнтэй бэлгийн хавьталд орсон залуучууд сүүлийн 12 жилийн хугацаанд 30 хувиар нэмэгдсэн (19 хувиас 49 хувьд хүрсэн), 2007 онд 2005 онтой харьцуулахад бэлгэвчийн хэрэглээ буурсан, мансууруулах бодис тарьж хэрэглэх нь 0,1 хувиас 0,2 хувь болж нэмэгдсэн зэрэг эрсдэлт зан үйлүүд нэмэгдсэн тухай судалгааны үр дүнгүүдээс дурьджээ.

Манай оронд болон хөрш зэргэлдээ орнуудад БЗДХ/ХДХВ/ДОХ-ын тархалт өндөр байгаа, Монгол залуучуудын дунд БЗДХ өвчний эрсдэлт зан үйл улам нэмэгдэж байгаа нь хүн амын БЗДХ/ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх мэдлэг, хандлага, дадлыг сайжруулах хэрэгцээг нэмэгдүүлж байна.

Монгол улсын Үндсэн хууль, Иргэний цэргийн болон цэргийн албан хаагчийн тухай хуульд зааснаар 18 нас хүрсэн эрэгтэй хүн бүр цэргийн алба хаах үүрэгтэй ба цэргийн алба хаах хугацаанд нь тэдний боловсролыг дээшлүүлэх төрөл бүрийн сургалтанд хамруулдгийн нэг нь 2002 оноос эхлэн хэрэгжиж буй эрүүл мэндийн боловсрол олгох хөтөлбөр юм. Хугацаат цэргийн албан хаагчаар дамжуулан залуучуудад бэлгийн замаар дамжих халдвараас

урьдчилан сэргийлэх мэдлэг, хандлага, дадал олгох нь зөвхөн цэргийн алба хаасан эрчүүдээр хязгаарлагдахгүй нийт хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд тодорхой ач холбогдолтой.

Цэргийн алба хааж буй залуучуудад явуулж буй нөхөн үржихүйн сургалтын чанар, явцаас шалтгаалан сургалтын үр дүн харилцан адилгүй байгаа талаар хэд хэдэн судалгааны тайланд дурьдсан байна. “Нийт эрэгтэйчүүдийн дийлэнх нь энэ талын мэдээллийг тогтвортой авах боломжтой болсон хэдий ч тус сургалтын чанар бэлтгэгдсэн сургагч нарын хүрэлцээ, идэвх санаачлагаас хамааран харилцан адилгүй байгаа. “Зарим аймаг, орон нутагт шинэ цэрэг татсаны дараагаар тэдэнд зориулсан НҮЭМ болон ХДХВ/ДОХ-ын чиглэлийн албан бус сургалтыг орон нутгийн НҮЭМ-ийн баг очиж явуулж хэвшсэн.” зэргээр тусгажээ. ²

“Сургалтын цаашдын тогтвортой байдлыг хангах үүднээс хөтөлбөрийг эрүүл мэнд, Батлан хамгаалах, БСШУ-ны сайдын хамтарсан тушаалаар албан ёсны болгож байнгын багш нарыг бэлтгэсэн нь сургалт тасралтгүй явагдах нөхцлийг бүрдүүлсэн байна. 2003 он гэхэд эрүүл мэндийг дэмжих өдөрлөгүүдийг ялангуяа залуучууд эрчүүд Зэвсэгт хүчний байгуулагуудад, эрчүүд зонхилсон газруудад зохион байгуулсны дүнд давхардсан тоогоор 28000 гаруй хүнийг хамруулан, жилд 2 удаа шинээр цэрэг татдаг ба нэг цэргийн ангид шинэ цэрэг таталтаар ойролцоогоор 60-70 хүн тогтмол ирдэг байна. Шинэ цэрэг татсаны дараагаар тэдэнд зориулсан НҮЭМ болон ХДХВ/ДОХ-ын чиглэлийн албан бус сургалтыг орон нутгийн НҮЭМ-ийн баг очиж явуулж хэвшсэн байлаа. Хугацаат цэргийн албан хаагчид цэргийн албанд 1 жилийн хугацааг өнгөрүүлдэг ба энэ хугацаанд зохих мэдлэгийг бүрэн авдаг байна” гэж цэргийн албан хаагчдын нөхөн үржихүйн сургалтын хөтөлбөрийг Монгол-Германы техник туслалцааны хамтарсан төслийн багаас үнэлжээ. ²

НҮБ-ын Хүн Амын Сангаас хэрэгжүүлсэн “Зэвсэгт хүчний байнгын бие бүрэлдэхүүн болон хугацаат цэргийн албан хаагчдыг БЗХӨ/ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх тухай” төслийн хүрээнд хугацаат цэргийн албан хаагчдад сургалт явуулах сургагч багш нарыг бэлтгэн, нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх 16 цагийн сургалтын хөтөлбөрт БЗХӨ/ХДХВ/ДОХ-ын 4 цагийн хичээлийг оруулсан байна. ³

БЗДХ/ХДХВ/ДОХ-ын талаарх хугацаат цэргийн албан хаагчдын мэдлэг, хандлага, дадлын түвшинг тодорхойлж, сургалтын хэрэгцээг тодорхойлох нь цаашид цэргийн албан хаагчдад явуулж буй БЗДХ/ХДХВ/ДОХ-ын албан

сургалтыг боловсронгуй болгох, сургалтаас олж авах мэдлэг, хандлага, дадлыг сайжруулах ач холбогдолтой.

1.2. Зорилго

БЗДХ/ХДХВ/ДОХ-ын талаарх хугацаат цэргийн албан хаагчдад хийгдэж буй сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох

1.3. Зорилт

1. БЗДХ/ХДХВ/ДОХ-ын талаарх хугацаат цэргийн албаа хааж буй залуусын мэдлэг, хандлага, дадлыг цэргийн албанд татагдах үеийн ба цэргийн албыг 6 сар хаасны дараах байдлаар харьцуулан судлах
2. Цэргийн алба хааж буй залуучуудад зориулсан БЗДХ/ХДХВ/ДОХ-ын хөтөлбөрийн агуулга, цаг багтаамж, сургалтын хэрэглэгдэхүүнийг үнэлэх
3. Хугацаат цэргийн албан хаагчдын БЗДХ/ХДХВ/ДОХ-ын сургалтын хөтөлбөр, хэрэгжилтийг боловсронгуй болгох санал, зөвлөмж боловсруулах

1.4. Хамгаалахаар дэвшүүлж буй асуудал

1. БЗДХ/ХДХВ/ДОХ-ын талаарх хугацаат цэргийн албан хаагчдын мэдлэг, хандлага, дадлын ялгаа, цэргийн алба хаасан хугацаагаар
2. БЗДХ/ХДХВ/ДОХ-ын талаарх хугацаат цэргийн албан хаагчдын сургалтын хөтөлбөрийн агуулга цаг багтаамжийн үнэлгээ
3. БЗДХ/ХДХВ/ДОХ-ын талаар Цэргийн албан хаагчдад мэдлэг, хандлага, дадлыг олгох сургалтын хөтөлбөр, орчинг боловсронгуй болгох санал

1.5. Судалгааны шинэлэг тал

1. БЗДХ/ХДХВ/ДОХ-ын талаарх хугацаат цэргийн албан хаагчдын цэргийн албанд татагдах, халагдах үеийн мэдлэг, хандлага, дадлын ялгааг гаргаж, цэргийн алба хаах хугацаанд энэ чиглэлээр олж авсан мэдлэг, хандлага, дадлыг үнэлсэн.

1.6. Судалгааны практик, ач холбогдол

1. БЗДХ/ХДХВ/ДОХ-ын өвчлөл нэмэгдэж байгаа өнөө үед БЗДХ/ХДХВ/ДОХ-ын талаарх хугацаат цэргийн албан хаагчдын сургалтын хөтөлбөрийн

- агуулга, цаг, сургалтын хэрэглэгдэхүүнийг үнэлж, сургалтын шинэчилсэн хөтөлбөрийн төслийг ЗХЖШтабын эрүүл мэндийн хэлтэст санал болгосон
2. БЗДХ/ХДХВ-ийн өвчлөл нэмэгдэж байгаа өнөө үед эрэгтэйчүүдийн БЗДХ/ДОХ-ын талаарх мэдлэг, хандлага, дадлыг нэмэгдүүлэх нь бэлгийн замаар дамжих халдварт өвчлөлийг бууруулахад чухал ач холбогдолтой арга хэмжээ
 3. Сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгосноор цаашид эмч, сувилагч нараар дамжуулан хугацаат цэргийн албан хаагчдад хүрэх, сургалтын хүртээмж сайжрах

1.7. Хэлэлцүүлсэн байдал

1. Судалгааны ажлын сэдэв, арга, аргачлалыг 2008 оны 04 сарын 14-ны Эпидемиологи, биостатистикийн тэнхимийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан./ протокол №7/
2. 2008 оны 05 дугаар сарын 7-ны өдөр, ЭМШУИС-ийн харьяа Био-анагаахын ёс зүйн зөвлөлийн хурлаар судалгааныхаа ажлын ёс зүй, таниулах зөвшөөрлийг хэлэлцүүлж, зөвшөөрөл авсан болно. протокол / №53/7/
3. Говь-Алтай аймгийн Анагаах ухааны коллежийн багш нарын хурлаар 2008 оны 09 сарын 25- ны өдөр хэлэлцүүлсэн.№ /7/
4. Эпидемиологи биостатистикийн тэнхимийн багш нарын хурлаар судалгааны ажлын явцыг 2008 оны 12 сарын 18, протокол / № 5/ 2009 оны 1 дүгээр сарын 16, /№6/ 29-нд /№7/ тус тус хэлэлцүүлсэн.
5. ЭМШУИС-ийн Биоанагаахын ёс зүйн зөвлөлийн 2009 оны 02 сарын 10-ны хурлаас судалгааны ажилд ёс зүйн дүгнэлт гаргуулсан протокол./№ 63/1/

1.8.Судалгааны ажлын ёс зүйн байдал

Энэ судалгааг анагаах ухааны ёс зүйн зарчмыг баримтлан хийсэн. Судалгаанд оролцогч бүрт судалгааны ажлын зорилгыг танилцуулж, судалгаанд өөрийн хүслээр оролцох, мэдээллийг зөвхөн эрдэм шинжилгээний зорилгоор хэрэглэхийг тайлбарлаж, оролцогч бүрээр таниулах зөвшөөрлийн хуудсанд гарын үсэг зуруулж баталгаажууллаа. Судалгаа хийх зөвшөөрлийг 2008 оны 05 дугаар сарын 7-ны өдөр, ЭМШУИС-ийн харьяа Био-анагаахын ёс зүйн зөвлөлийн хурлаар орж судалгаа хийх зөвшөөрөл, 2009 оны 02 сарын 10-ны өдөр судалгааны ажил нь ёс зүйн хэм хэмжээ зөрчөөгүй тухай дүгнэлт гаргуулсан болно.

1.9.Судлагдсан байдал

Монгол улсад хугацаат цэргийн албан хаагчдын БЗДХ/ХДХВ/ДОХ-ын мэдлэг, хандлага, дадлын түвшин болон нөхөн үржихүйн асуудлыг дараах судлаачид судалсан байна.

Судлаач Б. Сувд “Эрэгтэйчүүдийн НҮЭМ-ийн мэдлэг, хандлага, мэдээллийн хэрэгцээ”, 2003. магистрын ажлаараа Эрэгтэйчүүдийн НҮЭМ-ийн мэдлэг, хандлага, мэдээллийн хэрэгцээг хот хөдөөгийн НҮЭМ-ийн идэвхтэй насны хүмүүсийг хамруулан судалсан ба, судалгаанд Сүхбаатар, Булган, Хөвсгөл гэсэн 3 аймаг 9 сум, Улаанбаатар хотод НҮЭМ-ийн идэвхтэй насны нийт 1600 хүнийг хамруулан судалсан.

Судлаач Б. Солонго “НҮЭМ-ийн зарим асуудлын талаарх хугацаат цэргийн албан хаагчдын мэдлэг, хандлага” магистрын бүтээл, 2003. магистрын ажлаараа Улаанбаатар хот орчмын 5 цэргийн ангид татагдан ирсэн 18-25 насны залуучуудын НҮЭМ/ДОХ/БЗДХ-уудын талаарх мэдлэг, хандлага, дадал мэдээллийн хэрэгцээг тодорхойлон судалсан.

Цахим өртөө ТББ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл, БНСУ-д хөдөлмөр эрхэлж буй Монгол улсын иргэдийн БЗДХ/ХДХВ/ДОХ-ын талаарх мэдлэг, хандлага, дадлын судалгаа, 2007. Төслийн хүрээнд БНСУ-д хөдөлмөр эрхлэж буй Монгол улсын иргэдийн БЗДХ/ХДХВ/ДОХ-ын талаарх мэдлэг, хандлага, дадлын тухай үүн дотроо халдварлах зам, эрсдэлт зан үйл, бэлгэвчийн хэрэглээ, мэдээллийн байдал зэрэг асуудлыг судалсан.

Цахим өртөө ТББ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл, Их Британид амьдарч буй Монголчуудын БЗДХ/ХДХВ/ДОХ-ын талаарх мэдлэг, хандлага, дадал, эрсдэлт зан үйлийг тогтоох суурь судалгаа, 2008. Төслийн хүрээнд Их британид амьдарч буй монголчуудын дунд 2 үе шаттай хийгдэж байгаа ба , эхний шат нь Их Британид амьдарч буй Монголчуудын БЗДХ/ХДХВ/ДОХ-ын талаарх мэдлэг, хандлага, дадлыг судалж суурь мэдээлэлтэй болсноор мэдээллийн эх үүсвэр , шаардлагатай мэдээллийг тогтооход ач холбогдолтой. Төсөл хэрэгжисний дараа монголчуудын БЗДХ/ХДХВ/ДОХ-ын талаарх мэдлэг, хандлага, дадал өөрчлөгдсөнийг харьцуулан судлахад суурь мэдээлэлтэй болх зэрэг асуудлыг судалсан.

Олон улсын хэмжээнд цэргийн албан хаагчдыг БЗДХ/ХДХВ/ДОХ-ын өндөр эрсдэлт бүлэгт тооцож, тэдний энэ талын мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлсон олон судалгаа байдаг байна. ДЭМБ болон бусад нэгдсэн

үндэстний байгууллагууд, АНУ-ын халдварт өвчний төв /CDC/ гэх мэт судалгааны томоохон байгууллагуудын хийсэн зарим судалгаанаас дурьдвал:

- Елизабет Лоте нар, Гайтын энхийг сахиулагч хүчний цэргүүдийн дунд хийсэн ХДХВ, ДОХ-ын мэдлэг, хандлага, дадлын судалгаа, 2007
- Эрнест Еконг, Нигерийн цэргүүдийн дундах ХДХВ/ДОХ-ын тохиолдол, UNAIDS, Best practice collection, Женев, 1998
- ДЭМБ, БЗДХ/ХДХВ/ДОХ-ын халдварын мэдлэг, хандлага, дадлыг судалгаа, Косова, 2000, www.who.int/publication

1.10. Зохиолын бүтэц хэмжээ

Нэг сэдэвт бүтээлийг 5 бүлэг, 8 зураг 11 хүснэгт бүхий хэсгүүдийг агуулсан бөгөөд 54 хуудас бүхий Монгол хэл дээр бичигдсэн болно.

Ном зүй

1. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн мэдээ тайлан. (2008, 2009). Улаанбаатар : ХӨСҮТ
2. Уранчимэг. Д, Халтар. Ц. НҮЭМ-ийн салбарт дэмжлэг үзүүлэх Монгол Германы хамтарсан төслийн төгсгөлийн үнэлгээ. (2006) ЭМЯ, ГТХАН. ISBN
3. ЭМЯ, Зэвсэгт хүчний жанжин штаб, Хил хамгаалах ерөнхий газар. Цэргүүдэд зориулсан сургалтын хөтөлбөр. (2002-2006) Улаанбаатар
4. НҮБ-ын Дох-ын эсрэг байгууллага, ДЭМБ. ДОХ-ын тархалтын өнөөгийн байдал (2007).Улаанбаатар: UB print
5. Сувд. Б. Эрэгтэйчүүдийн НҮЭМ-ийн мэдлэг, хандлага, мэдээллийн хэрэгцээг судалсан нь. (2003) Магистрын зэрэг горилсон бүтээлийн хураангуй. ЭМШУИС. 2003.
6. Солонго. Б. НҮЭМ-ийн зарим асуудлын талаарх хугацаат цэргийн албан хаагчдын мэдлэг, хандлагын байдал. (2003) Магистрын зэрэг горилсон судалгааны ажил. ЭМШУИС. 2003.
7. Дэмбэрэлсүрэн. Ж. (2002) Нөхөн үржихүйн эрүүл мэндийн суурь судалгаа. Улаанбаатар:
8. Нямдаваа. П. (2002-2006) Монгол улсын Нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр. Улаанбаатар: ЭМЯ,НҮБ-ын хүн амын сан.
9. Глобал сангаас хэрэгжүүлж буй төсөл, судалгааны тайлан / [http:// erchuud.Blogspot.com/](http://erchuud.Blogspot.com/) 2008 он 12 сарын 14 өдрийн 14 цаг 30 минут , / [http:// www.acie.edu.mn./](http://www.acie.edu.mn./) node 80 2008 он 12 сарын 14 өдрийн 14цаг 18минут
- 10.ЭМЯ,НҮБ-ын хүн амын сан. (2004) НҮЭМ-ийн хөтөлбөрийн удирдлага сайжруулах арга хэрэгсэлийн цомог. Модуль 8. Улаанбаатар: UB print ICOMP
11. ЭМЯ, Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төв. (2008). Эрүүл мэндийн үзүүлэлтүүд (2007) УБ: Улаанбаатар
- 12.Аюуш. Б. Өсвөр үеийнхний НҮЭМ-ийн талаарх мэдлэг, хандлага, дадал. (2006) Магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. ЭМШУИС.
- 13.ДЭМБ. Номхон далайн баруун эргийн бүсийн алба Манила (2001) БЗДХ-ын хам шинжийн оношлогоо эмчилгээ. Улаанбаатар: Тоонотпринт.
- 14.Амар мэнд. Сэтгүүл. (2001,2006). Улаанбаатар: Colorteam.

15. HIV/AIDS Knowledge, Attitude and Practice survey: UN Uniformed Peacekeepers in Haiti, August 2007, <http://pbpu.unlb.org/pbps/library/KAPsurvey>.
16. Сонин. С, Дашзэвэг. Г, Энхтуяа. С. (2007) Нийгмийн эрүүл мэнд. Улаанбаатар: Эрүүл мэндийн салбарын хөгжил төсөл 2.
17. Лхагвасүрэн. З, Бадамсэд. Ц. (2006) Эрдэм шинжилгээний илтгэл өгүүллийн эмхтгэл. Улаанбаатар: СОФЕКС ХХК.
18. Чойжамц. Г, Пүрэвсүрэн. (2008) НҮЭМ-ийн тусламж үйлчилгээ үзүүлэгч нарын сургалтын мастер төлөвлөгөөний шинэчлэл. Улаанбаатар хот:
- 19.
20. Буяндэлгэр. Т. (2006) Оюутны эрдмийн чуулган. Улаанбаатар: Оюутны эрдэм шинжилгээний нийгэмлэг. ЭМШУИС
21. Бямбасүрэн. П, Цэрэнханд. Б, Ойдовданзан, Р. (2004) Нөхөн үржихүйн эрүүл мэндийн суурь суурь судалгаа Улаанбаатар:
22. Бямбацэрэн. П, Цэрэнханд. Б, Ойдовданзан. Р, Жав Б, (2003) Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа. Улаанбаатар:
23. Энхмаа. Ө, Илиза. А. (2003) Нөхөн үржихүйн эрүүл мэнд үргүйдэл, үр хөндөлт. Улаанбаатар: МУЗН.
24. Чимэдсүрэн. О. (2004) Эпидемиолгийн судалгааны арга зүй. Улаанбаатар: ISBN.
25. Булганчимэг. Б, Оюунгэрэл. Н, (2000) 15-25 насны залуучуудын ХДХВ,/ ДОХ/ БЗХӨ-ний талаарх мэдлэг, хандлага, дадал үндэсний судалгаа. Улаанбаатар: ЭМШУИС.
26. Цэцгээ. Ж, Амартүвшин. Б, (2005) Мухар олгойн цочог үрэвслийн хэт авийн оношлогоо. Улаанбаатар: ЭМШУИС. Эрхэс.
27. Бат-Эрдэнэ, И, Энхзаяа. Ш. (2006) Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах. Улаанбаатар: ХҮЛЭГ ТАЙЖ. ХХК.
28. Энхмаа. Ө, Илиза. А. (2003) Гэр бүл төлөвлөлт. Улаанбаатар: МУЗН
29. Ганганноров. Д, Гармаа. В. (2003) ХДХВ/ДОХ ба БЗДХ-ын тухай. Улаанбаатар: МУЗН.

30. Дамиен Вольфрат, Жин Альборг, Жав. Б, Шижирбаатар. Б, Пүрэвсүрэн. Г, ' болон бусад ' (2000) НҮЭМ-ийн тусламж үйлчилгээний клинкийн удирдамж. Улаанбаатар: МЭЭЭН.
31. Амарсанаа. Э. Хөхний өмөн үүсэхэд нөлөөлөх зарим эрсдэлт хүчин зүйлс. (2009) Докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. ЭМШУИС.
32. Идэр. Д, Хандсүрэн. Б. (2009) Жирэмсэн эмэгтэйчүүдийн бэлгийн замаар дамжих илрэл. Эрдмийн чуулган-51. Х 56
33. Отгонболд. А. (2007) Тооны цаана. Жирэмсний хүндрэл эхийн өвчлөл, эндэгдлийг судлах аргыг эзэмшүүлэх сургалтын гарын авлага. Улаанбаатар: ADB.
34. Дэмбэрэлсүрэн. Ж, Базаррагчаа. Ц, Сувд. Б, (2001) Нар үр хөндөлтийн шалтгааныг ЖСА болон нийгмийн хүчин зүйлтэй холбон судалсан нь судалгааны тайлан. Улаанбаатар.
35. Содномпил. Ц, Оюунбилэг. М, (1996) Өсвөр үеийнхний эрүүл мэндийг хамгаалах мэдлэг, зан үйл, дадал, хандлага. Улаанбаатар: ЭМШУИС
36. Цолмон. Х, НҮЭМ-ийн төлөө байдлын асуудалд. (2006) Магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. ЭМШУИС.
37. Янжинсүрэн. Д, Байгалмаа. Д, Сувд. Б, Болормаа. Н, Наранцэцэг. В, (2005) Өсвөр үеийнхэнд ээлтэй НҮЭМ-ийн үйлчилгээ Улаанбаатар:
38. Хоролсүрэн. Н, Оюунцэцэг. Л. (2004) Багшийн гарын авлага. Улаанбаатар: ЭМШУИС. Эрхэс.